



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

᠑᠔᠔᠔ оны ᠐7 сарын ᠐1 өдөр

Дугаар А/34᠖

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны Журам шинэчлэн батлах тухай 206 дугаар тогтоол, 2021 оны Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 374 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг нэгдүгээр, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацааг хоёрдугаар, холбогдох баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах хүснэгтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг яамны газар, хэлтэс, харьяа эрүүл мэндийн байгууллага, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, ерөнхий захирал нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн салбарын холбогдох эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах мэдээллийн цахим сан үүсгэж, тогтмол ажиллагааг хангахыг Бодлого төлөвлөлтийн газарт даалгасугай.

4. Жил бүр улсын хэмжээнд хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээг зохион байгуулж, дүн тайланг журмын дагуу эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлж байхыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ц.Эрдэмбилэг)-д даалгасугай.

6. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн А/605, 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А/578 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141221649

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ
НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмыг эрүүл мэндийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, эрүүл мэндийн байгууллага (ЭМБ)-ын үйл ажиллагааны болон салбарын бусад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд мөрдөнө.

1.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ)-ний зорилго нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, эрүүл мэндийн байгууллагын болон бусад үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг сайжруулж, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим

- 2.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:
- 2.1.1. шударга, хараат бус байх;
 - 2.1.2. хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа нээлттэй, тэдгээрээс гарсан тайлан, дүгнэлт нь ил тод байх;
 - 2.1.3. хяналт-шинжилгээ, үнэлгээ нь шалгуур үзүүлэлт, тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
 - 2.1.4. үр дүнд чиглэсэн байх;
 - 2.1.5. хяналт-шинжилгээг тасралтгүй, үнэлгээг тогтмол, тодорхой үе шаттай хийдэг байх;
 - 2.1.6. хэрэглэгч, оролцогч талуудын оролцоог хангасан байх.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ

3.1 Эрүүл мэндийн салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээнд дараах бодлогын баримт бичгийн хэрэгжилт; хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт; байгууллагын үйл ажиллагааны үнэлгээ; хэрэглэгчийн үнэлгээ болон бусад үнэлгээ багтана.

3.1.1 Эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж байгаа бодлогын баримт бичигт дараах баримт бичгүүд хамаарна. Үүнд:

- 3.1.1.1 “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- 3.1.1.2 Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр
- 3.1.1.3 Монгол Улсыг хөгжлүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- 3.1.1.4 Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө
- 3.1.1.5 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр

- 3.1.1.6 Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ
- 3.1.1.7 Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр
- 3.1.1.8 Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр
- 3.1.1.9 Эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
- 3.1.2 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрт дараах баримт бичиг хамаарна. Үүнд:
 - 3.1.2.1 Монгол Улсын хууль
 - 3.1.2.2 Улсын Их Хурлын тогтоол
 - 3.1.2.3 Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол
 - 3.1.2.4 Ерөнхийлөгчийн зарлиг
 - 3.1.2.5 Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр
 - 3.1.2.6 Засгийн газрын тогтоол
 - 3.1.2.7 Ерөнхий сайдын захирамж
 - 3.1.2.8 Засгийн газрын хуралдааны тэмдэглэл
 - 3.1.2.9 Засгийн газрын болон Ерөнхий сайдын албан даалгавар
 - 3.1.2.10 Эрүүл мэндийн сайдын тушаал, албан даалгавар
- 3.1.3 Байгууллагын үйл ажиллагаанд дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:
 - 3.1.3.1 Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт
 - 3.1.3.2 Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт
 - 3.1.3.3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт
 - 3.1.3.4 Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт
 - 3.1.3.5 Хэрэглэгчийн үнэлгээ
- 3.1.4 Бусад үнэлгээнд эрүүл мэндийн салбарын дараах үнэлгээг хамруулан ойлгоно. Үүнд:
 - 3.1.4.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ
 - 3.1.4.2 Эмнэлзүйн удирдамж, зааврын хэрэгжилт
 - 3.1.4.3 Эрүүл мэндийн технологи, инноваци
 - 3.1.4.4 Зайлшгүй шаардлагатай эмийн хангамж, эмийн чанар, аюулгүй байдал
 - 3.1.4.5 Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүн
 - 3.1.4.6 Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой гомдлын шийдвэрлэлт
 - 3.1.4.7 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн
 - 3.1.4.8 Болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, онцгой байдлын үеийн бэлэн байдал хангах, хариу арга хэмжээний болон нөхөн сэргээх үеийн төлөвлөгөө, хэрэгжилтийн байдал
 - 3.1.4.9 Байгууллагын эрсдэлийн удирдлага, эрсдэл бууруулах төлөвлөгөө, хэрэгжилтийн байдал
 - 3.1.4.10 Байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран ажилласан байдал, хамтын гэрээний хэрэгжилтийн үр дүн
 - 3.1.4.11 Байгууллагын дотоод хяналтын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн

**Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлага,
зохион байгуулалт**

4.1. Эрүүл мэндийн байгууллага нь өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байна.

4.2. Эрүүл мэндийн яам нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, дэмжлэгт хяналт тавих, мэдээлэх үүргийг хариуцна.

4.3. Захиргаа, хүний нөөц, дотоод ажил хариуцсан нэгж нь /ЭМЯ-нд Төрийн захиргааны удирдлагын газар/ бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Төрийн албан хаагч бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв, бодитой гаргаж өгөх үүрэгтэй.

4.4. Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчид тавих шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан хүнийг хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан тушаалд томилоно:

4.4.1. хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр болон тухайн салбарт гурваас доошгүй жил ажилласан туршлагатай байх

4.4.2. хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр гадаад, дотоодын сургалтад хамрагдсан байх

4.4.3. баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх

**Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний
төлөвлөлт, зохион байгуулалт**

5.1 Эрүүл мэндийн байгууллага нь жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг батална. Энэхүү төлөвлөгөө нь тухайн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж буюу ажилтны төлөвлөгөө байж болно. Төлөвлөгөөнд ХШҮ-ний үндэслэл, шалгуур үзүүлэлт, түүний суурь болон зорилтот түвшин, хариуцах нэгж, хэрэгжүүлэх хугацаа, зардал зэргийг тусгана.

5.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээг байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцыг хянах, мэдээлэх зорилгоор тасралтгүй хийнэ.

5.3 Үнэлгээний зорилгоос хамааруулан урьдчилсан, явцын болон гүйцэтгэлийн үнэлгээ хийх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдамжид ямар хэлбэрээр үнэлгээ хийх талаар нарийвчлан тусгана.

5.4 Хөндлөнгийн үнэлгээг урьдчилсан, явцын болон гүйцэтгэлийн үнэлгээний аль ч шатанд хийж болох бөгөөд хөндлөнгийн мэргэжлийн байгууллага, судлаачдаар хийлгэнэ.

5.5 Холбогдох бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэх үүргийг үндэсний түвшинд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрүүл мэндийн байгууллагад тэдгээрийн дарга, ерөнхий захирал нар хариуцна.

5.6 Энэхүү журмын 3.1.1 ба 3.1.2-т заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг 3 дугаар хавсралтын холбогдох хүснэгтийн дагуу гаргаж, 2 дугаар хавсралтаар тогтоосон хугацаанд холбогдох газарт хүргүүлэх ба Засгийн газрын ХШҮ-ний мэдээллийн цахим санд оруулна.

5.7 Энэхүү журмын 3.1.3-т заасан байгууллагын үйл ажиллагааны үнэлгээний 3.1.3.3-т заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтийг гаргах, нэгтгэх үүргийг Эрүүл мэндийн хөгжлийн төв гүйцэтгэж, тайланг 2 дугаар хавсралтаар тогтоосон хугацаанд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжид ирүүлнэ.

5.8 Энэхүү журмын 3.1.3.5-д заасан хэрэглэгчийн үнэлгээ нь эрүүл мэндийн салбарын хэрэглэгчийн санал бодлыг харгалзан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгох зорилготой. Хэрэглэгчийн үнэлгээг эрүүл мэндийн байгууллагууд дотооддоо хийж гүйцэтгэх ба салбарын нэгдсэн үнэлгээг Эрүүл мэндийн хөгжлийн төв хариуцан зохион байгуулна.

5.8.1 Эрүүл мэндийн байгууллагууд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

5.8.1.1 Дотооддоо өөрийн үзүүлж буй тусламж, үйлчилгээний чиглэлээр хэрэглэгчийн үнэлгээг тогтмол зохион байгуулна.

5.8.1.2 Үнэлгээний үр дүнг чанарын алба, нэгж болон бусад холбогдох тасаг, нэгжүүд чанар сайжруулах арга хэрэгсэл болгон ашиглана.

5.8.1.3 Дотооддоо зохион байгуулсан үнэлгээний дүн, тайланг бодлого, үйл ажиллагаандаа тусгаж, тайланг 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор гарган Эрүүл мэндийн хөгжлийн төвийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

5.8.2 Эрүүл мэндийн хөгжлийн төв нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

5.8.2.1 Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн нэгдсэн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

5.8.2.2 Үнэлгээний ажлын удирдамжид хэрэглэгчийн үнэлгээний зорилго, зорилт, үйл ажиллагааны хүрээ, эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо болон аймаг, нийслэлд үйлчлэх хүрээний хүн амын тоог харгалзсан түүврийн хэмжээ, санал асуулгын агуулга,

- үнэлгээний аргачлал, үнэлгээ хийх хугацаа, зардал, тайлагналт, үнэлгээний байгууллага, багт тавигдах шаардлага зэргийг тусгана.
- 5.8.2.3 Үнэлгээний асуумж судалгааг цахим эсвэл цаасан хэлбэрээр нэгдсэн байдлаар авах боломжийг бүрдүүлж, эрүүл мэндийн байгууллагуудад заавар зөвлөмжийг өгч ажиллана.
- 5.8.2.4 Салбарын хэмжээнд зохион байгуулсан үнэлгээ болон байгууллагын дотооддоо зохион байгуулсан үнэлгээний дүн, тайланг нэгтгэж, дүгнэлт, зөвлөмжийн хамт албан бичгээр эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжид жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.
- 5.8.3 Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж буй хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг авахдаа тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг харгалзан асуумж боловсруулж гүйцэтгэнэ.
- 5.8.4 Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээний дүнг эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны тухайн жилийн гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээнд шууд ашиглана.
- 5.8.5 Эрүүл мэндийн байгууллага болон Эрүүл мэндийн хөгжлийн төв нь Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээний дүнг байгууллагын цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр олон нийтэд ил тод мэдээлнэ.
- 5.9 Энэхүү журмын 3.1.4-д заасан ХШҮ-г эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон бусад эрүүл мэндийн байгууллагын холбогдох нэгж зайлшгүй шаардлагаар Эрүүл мэндийн сайд болон Төрийн нарийн бичгийн дарга, тухайн байгууллагын дарга, захирлын баталсан удирдамжын дагуу тусгайлан хийж гүйцэтгэнэ.
- 5.10 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын цар хүрээ, хугацаа, хүний нөөцийг удирдамжаар тодорхойлно. ХШҮ хийх ажлын хэсэг, удирдамжийг Эрүүл мэндийн сайд, Төрийн нарийн бичгийн дарга, байгууллагын дарга, захирлаар батлуулж, ажлын хэсгийн бүрэлдэхүүний 20 хүртэлх хувийг ХШҮ-ний чиглэлээр мэргэшсэн судлаачид, мэргэжлийн байгууллагын төлөөллөөс бүрдүүлж болно.
- 5.11 Ажлын хэсгийн ажиллах хэлбэр нь хурал байна. Хурлаас тэмдэглэл гарах бөгөөд уг тэмдэглэлд хуралд оролцогчид, гишүүдийн ирц, хэлэлцэх асуудлын агуулга, асуудлыг хэлэлцсэн явц болон хурлаас гарсан шийдвэрийг тус тус тусган, хуралд оролцсон гишүүдийн гарын үсгийг зурж баталгаажуулна.
- 5.12 Ажлын хэсгийн хурлыг нийт гишүүдийн дийлэнх олонх оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцож, ердийн олонхын саналаар шийдвэр гаргана.

5.13 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ баримт бичиг судлах, холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцах, санал асуулга явуулах, ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгах зэрэг дүн шинжилгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

5.14 Эрүүл мэндийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ыг баримтлан дүгнэнэ.

Зургаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

6.1 Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ урьдчилан тодорхойлсон тоон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг дараахь аргачлалын дагуу хувиар илэрхийлэн үнэлнэ:

$$\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} \cdot 100\%$$

6.2 Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг тодорхойлоход дараахь аргачлалаар тооцно:

6.2.1 зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь

6.2.2 тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол 70.0 хувь

6.2.3 тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол 50.0 хувь

6.2.4 тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол 30 хувь

6.2.5 тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийг "0" хувь.

6.3 Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг энэ журмын 6.1, 6.2-т заасан аргачлалын дагуу тооцох ба нийт зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн арифметик дунджийг тооцож, зорилго, зорилтын хэрэгжилтийг дараахь ангилалд шилжүүлэн ерөнхий үнэлгээ өгнө:

- 6.3.1 “үр дүнтэй”-зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь
- 6.3.2 “тодорхой үр дүнд хүрсэн”-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70-99 хүртэл хувь
- 6.3.3 “эрчимжүүлэх шаардлагатай”-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай бол 31-69 хүртэл хувь
- 6.3.4 “үр дүнгүй”-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 0-30 хүртэл хувь.

6.4 Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, заалт тус бүрийн хэрэгжилтийн хувийг дараах аргачлалаар тооцно:

- 6.4.1 “бүрэн хэрэгжсэн”-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);
- 6.4.2 “хэрэгжих шатанд”-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол 70 хувь (50-89 хүртэл хувь);
- 6.4.3 “хэрэгжилт хангалтгүй”-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй бол 30 хувь (10-49 хүртэл хувь);
- 6.4.4 “хэрэгжээгүй”-тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа, бэлтгэл ажил хийгдэж боловсруулалтын шатанд байгаа болон тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 хувь (0-9 хүртэл хувь);
- 6.4.5 “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”.

6.5 Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн ерөнхий дүнг гаргахдаа зүйл, заалт бүрийн хэрэгжилтийн арифметик дунджийг тооцож, 6.3-т заасан ангилалд шилжүүлж, ерөнхий үнэлгээг өгнө.

6.6 Эрүүл мэндийн байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн үнэлгээний дүнг гаргахдаа үзүүлэлт бүрийн үнэлгээг 100 хүртэл хувиар илэрхийлэн нийлбэр үнэлгээний арифметик дунджийг харгалзах жинд шилжүүлнэ. Ерөнхий үнэлгээг тодорхойлохдоо жинд шилжүүлсэн дүнгүүдийн нийлбэрийг 0.05-аар үржүүлж, 0-5 хүртэл ононд шилжүүлэн дүгнэнэ:

- Е- ерөнхий үнэлгээ;
 α - гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;
 β - эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтийн хувь;
 γ - төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт;
 μ - мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хувь;
 τ - хэрэглэгчийн үнэлгээ;
 n - гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээний тоо;
 m - шалгуур үзүүлэлтийн тоо;
 k - хүний нөөцийг чадавхижуулах арга хэмжээний тоо;
 Ω – ил тод байдлын үзүүлэлтийн тоо;
 i – үзүүлэлтийн дугаар;

$$E = \sum_{i=1}^n (\alpha_i) * 0.2 + \sum_{i=1}^m (\beta_i) * 0.3 + \sum_{i=1}^k (\gamma_i) * 0.15 + \sum_{i=1}^{\Omega} (\mu_i) * 0.15 + \tau * 0.2$$

6.7 Эрүүл мэндийн байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээг дараах байдлаар дүгнэнэ. Үүнд:

“А” буюу “Маш сайн”	90-100 хувь (4.50-5.00 оноо)
“В” буюу “Сайн”	80-89.0 хувь (4.00-4.49 оноо)
“С” буюу “Хангалттай”	70-79.0 хувь (3.50-3.99 оноо)
“D” буюу “Дутагдалтай”	60-69.0 хувь (3.00-3.49 оноо)
“F” буюу “Хангалтгүй”	0-59.0 хувь (0.00-2.99 оноо)

6.8 Эрүүл мэндийн байгууллагууд дотооддоо жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний танилцуулга, дүнг байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хурлаас гарсан дүгнэлт, зөвлөмжийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжид ирүүлнэ.

6.9 Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, стратеги төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхдээ бодлогын баримт бичиг үнэлэх аргачлал, байгууллагын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааг үнэлэхдээ хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ тооцдог аргачлалыг тус тус баримтална.

6.10 Хэрэгжилтийн тайланг дээд шатны байгууллагад тайлагнахдаа тухайн зорилт, арга хэмжээ, заалтын гүйцэтгэл, үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаах ба шаардлагатай бол нэмэлт баримтыг файлаар хавсаргаж болно.

Долоо. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

7.1 Бодлогын баримт бичгийн хэрэгжилт; хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хийх ХШҮ-г Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын 7, 8-р зүйлийг баримтлан хийж гүйцэтгэнэ.

7.2 Эрүүл мэндийн байгууллагын гүйцэтгэлийг үнэлэхдээ тухайн байгууллагаас ирүүлсэн тайлан, жилийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээнд тулгуурлан гүйцэтгэнэ. Тайлан нь дараах хавсралттай байна:

7.2.1 тухайн жилийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт (3 дугаар хавсралтын хүснэгт 3.5)

7.2.2 төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт (3 дугаар хавсралтын хүснэгт 3.6)

7.2.3 мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт (3 дугаар хавсралтын хүснэгт 3.7)

7.2.4 эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт (3 дугаар хавсралтын хүснэгт 3.8)

7.3 Эрүүл мэндийн байгууллагууд нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг энэхүү тушаалын 3 дугаар хавсралтын хүснэгт 3.5-3.8-ын дагуу гаргаж, тайланг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухайн жилийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.

7.4 Салбарын шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг Эрүүл мэндийн яамны ХШҮ-ний нэгж нэгтгэн гаргана.

Найм. Мэдээллийн цахим сан

8.1 Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, тайлан илгээх, хүлээн авах, мэдээллийн урсгалыг удирдах, хянах, хадгалах, ашиглах, түгээхэд эрүүл мэндийн салбарын мэдээллийн цахим санг ашиглана.

8.2 Цахим сан үүсгэх, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, ашиглах зааврыг Эрүүл мэндийн сайд баталж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Бодлого, төлөвлөлтийн нэгж нь эрүүл мэндийн байгууллагыг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.

8.1 Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хийсэн холбогдох хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд зааврын дагуу тайлагнаж оруулна.

8.2 Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд чиг үүргийн дагуу нэвтрэх эрхийн хүсэлтийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын ХШҮ-ний нэгжид гаргаж, хэрэглэгчийн нэр, код үүсгэж авна.

8.3 Цахим санд мэдээлэл оруулж байгаа нэгжийн албан хаагч мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хариуцна.

8.4 Хэрэгжилтийн тайланг цахим санд оруулахдаа тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаах бөгөөд шаардлагатай бол нэмэлт баримтыг файлаар хавсаргаж болно.

8.5 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын удирдлагууд цахим санд өөрийн эрхээр нэвтэрч холбогдох эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайлантай танилцаж болно.

8.6 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дор дурдсан асуудлыг хариуцна:

8.6.1 мэдээллийн сан, сүлжээний хэвийн, найдвартай ажиллагаа болон програм хангамж, системийн зохицуулалт, нэвтрэх эрх авах

8.6.2 цахим санд өөрт олгосон эрхийн дагуу бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн заалт нэг бүрийг хяналтад авч хэрэгжүүлэх байгууллагатай холбогдон тайлагнах хугацааг зааж, холбогдох өөрчлөлтийг тухай бүр хийх

8.6.3 цахим санд өөрт оногдсон эрхийн дагуу нэвтэрч, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

8.6.4 цахим сангийн үйл ажиллагаатай холбоотой сургалт, зааварчилгаа, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах

8.7 Эрүүл мэндийн байгууллага дараах асуудлыг хариуцна:

8.7.1 байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн болон тухайн асуудал хариуцсан ажилтан цахим санд нэвтэрч, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг энэхүү тушаалын 2 дугаар хавсралтад заасан хугацаанд оруулах;

8.7.2 бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн мэдээ, тайланг удирдлага, даргын зөвлөл, хурлаар хэлэлцүүлсний дагуу цахим санд оруулан баталгаажуулж, холбогдох байгууллагад албан бичгээр хүргүүлэх;

8.7.3 холбогдох байгууллагаас өгсөн үнэлгээтэй тухай бүр танилцаж, өгсөн удирдамж, зааврыг мөрдөн ажиллах.

8.8 Цахим сан нь ил тод байдлыг хангах зорилгоор олон нийтэд зориулагдсан нээлттэй хэсэгтэй байна.

Ес. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

9.1 Эрүүл мэндийн байгууллага, түүний удирдлага, албан тушаалтан нь хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд дурдсан зөвлөмж, дүгнэлтийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана.

9.2 Эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд тэргүүний арга, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтийн хүртээл болгох, гарсан алдаа, дутагдлыг засч, залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

9.3 Эрдэмтэн, судлаачдыг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд татан оролцуулах, хэрэглэгчийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх, сургалт зохион байгуулах, сургалтын материал, ном, товхимол, гарын авлага хэвлүүлэх зэрэг зардлыг өөрийн байгууллагын төсөвт жил бүр тусган батлуулна.

9.4 Жилийн үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан гурван байгууллага тус бүрд "Өргөмжлөл", мөнгөн урамшуулал эсвэл үнэ бүхий зүйл олгож болно.

Арав. Хариуцлага

10.1 Үнэлгээний дүнгээр "Дутагдалтай" болон "Хангалтгүй" гэж дүгнэгдсэн байгууллагын удирдлагад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

10.2 Дараахь зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хуульд зааснаар хариуцлага хүлээлгэнэ:

10.2.1 Энэхүү журамд заасныг зөрчиж худал, зөрүүтэй мэдээллээр тайлагнасан, тогтоосон хугацаанд тайлагнаагүй тохиолдолд;

10.2.2 хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, тайланг байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлээгүй.

07 Эрүүл мэндийн сайдын 2022 оны
сарын 01-ны өдрийн 4340 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт


ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ,
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ БОЛОН
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАЙЛАГНАХ ХУГАЦАА

№	Тайлангийн төрөл	Тайлан хүлээн авч нэгтгэх		Нэгтгэсэн тайлан хүлээн авч ХШҮ хийх		Үнэлгээг тайлагнах	
		Байгууллага/газар, хэлтэс	хугацаа	Байгууллага/газар, хэлтэс	хугацаа	Байгууллага/газар, хэлтэс	хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Бодлогын баримт бичиг	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050"	Эрүүл мэндийн яам, Газар, хэлтсүүд	08.01	Эрүүл мэндийн яам, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	08.15	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	09.01-ний өдрийн дотор
	Хөгжлийн зорилтот хөтөлбөр	Эрүүл мэндийн яам, Газар, хэлтсүүд	07.01	Эрүүл мэндийн яам, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	07.15	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	08.01-ний өдрийн дотор
	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Эрүүл мэндийн яам, Бодлого төлөвлөлтийн газар	12.01	Эрүүл мэндийн яам, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	12.15	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	01.01-ний өдрийн дотор /ХШҮ 2 жил тутам/
	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө	Эрүүл мэндийн яам, Бодлого төлөвлөлтийн газар	12.01 06.01	Эрүүл мэндийн яам, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	12.15 06.05	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	01.01-ний өдрийн дотор, 06.15-ны өдрийн дотор цахим системээр
	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	Эрүүл мэндийн яам, Бодлого төлөвлөлтийн газар	12.01 06.01	Эрүүл мэндийн яам, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	12.15 06.15	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	01.01-ний өдрийн дотор, 07.01-ний өдрийн дотор цахим системээр

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	Монгол Улсын хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэр	Эрүүл мэндийн яам, Төрийн захиргааны удирдлагын газар	01.01 06.01	Эрүүл мэндийн яам, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	01.15 06.15	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	02.15-ны өдрийн дотор, 07.10-ны өдрийн дотор
Төсөл	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт	Эрүүл мэндийн яам, Төрийн захиргааны удирдлагын газар	01.15	Эрүүл мэндийн яам, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	02.01	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	03.01-ний өдрийн дотор
Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ	Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	Эрүүл мэндийн яам, Төрийн захиргааны удирдлагын газар	01.15	Эрүүл мэндийн яам, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	02.01	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	03.01-ний өдрийн дотор
Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа	1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	Эрүүл мэндийн яам, Төрийн захиргааны удирдлагын газар	12.15	Эрүүл мэндийн яам, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	01.15	Эрүүл мэндийн яам	03.01-ний өдрийн дотор
	2.Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт						
	3.Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт						
	4.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт	Эрүүл мэндийн хөгжлийн төв					
	5.Хэрэглэгчийн үнэлгээ						
Шилэн данс	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Эрүүл мэндийн байгууллагууд	02.01	Эрүүл мэндийн яам, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	02.15	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	03.01-ний өдрийн дотор

Эрүүл мэндийн яамны үйл ажиллагаа	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	Эрүүл мэндийн яам, Төрийн захиргааны удирдлагын газар	12.10 06.10	Эрүүл мэндийн яам, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	12.25 06.25	Эрүүл мэндийн яам	01.01-ний өдрийн дотор
	Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт		01.01		01.15	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	02.01-ний өдрийн дотор
	Тухайн жилийн үйл ажиллагааны үнэлгээ		02.01		02.15		03.01-ний өдрийн дотор

07 Эрүүл мэндийн сайдын 2022 оны
 ... сарын 07 -ны өдрийн 4/... дугаар
 тушаалын гуравдугаар хавсралт



ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
 БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

Хүснэгт 3.1

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар)
				Он	Түвшин	Он	Түвшин	
Бодлогын баримт бичгийн зорилго 1								
1.	Зорилт 1							
1.1.	Арга хэмжээ							
1.2.	Арга хэмжээ							
1.3.	Арга хэмжээ							
Бодлогын баримт бичгийн зорилго 2								
2.	Зорилт 2							
2.1.	Арга хэмжээ							
2.2.	Арга хэмжээ							
2.3.	Арга хэмжээ							

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

Хүснэгт 3.2

ЗГҮАХ-т тусгагдсан зорилт	Дугаар	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)		Хэрэгжилтийн хувь
						Он	Хүрсэн түвшин, үр дүн	
1	2	3	4	5	6	7	8	9
ХӨГЖЛИЙН САЛБАР №1.1.								

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

